



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/III

Хэрлэн сум

Галзуу өвчинтэй тэмцэх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зооноз өвчин болох мал, амьтны галзуу өвчний гаралт, тархалт ихсэж эрсдэл өндөр байгаа тул уг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Ц.Гэрэлмаа	Эрүүл мэндийн газрын дарга
	Г.Наранхүү	Зооноз өвчин судлалын төвийн дарга
	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Н.Чанцал	Онцгой байдлын газрын дарга
	Г.Мандах	Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга

2. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

3. Аймаг, орон нутгийн хэмжээнд эрсдэл өндөртэй бүс нутгийг тогтоож тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан биелэлтийг сар бүр тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА